



## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Халхгол сумын Музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/244/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: У.Энхчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
Менежментийн захидал .....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.01.24 № 154

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАЛХГОЛ СУМЫН ЯЛАЛТ МУЗЕЙН  
ЗАХИРАЛ Л.МЯГМАРСҮРЭН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын Ялалт музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Халхгол сумын Ялалт музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Халхгол сумын Ялалт музейн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520072



### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

"Халхгол сумын Ялалт музей" -ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Л.Мягмарсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Халхгол сумын Ялалт музей" -ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Халхгол сумын Ялалт музей"-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар "Хаан консалтинг аудит" ХХК-ийн аудитор У.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

"Халхгол сумын Ялалт музей"-ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

"Халхгол сумын Ялалт музей"-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Соёлын үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, эх оронч үзлээр хүмүүжүүлэх, уламжлуулах, иргэдийн соёлын биет болон биет бус өвийн мэдлэгийг дээшлүүлж, танин мэдэхүйн мэдээлэл сургалт сурталчилгааны төв болоход оршино.

"Халхгол сумын Ялалт музей"-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Музейн гол зорилт нь соёлын үйлчилгээ, хүртээмжийг хөгжүүлж, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус "Халхгол сумын Ялалт музей" -ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Халхгол сумын Ялалт музей" нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахрорег программ хангамж ашигладаг байна.

"Халхгол сумын Ялалт музей"-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар "Халхгол сумын Ялалт музей" -ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 229,415.9 мянган төгрөгөөс тооцон 4,588.32 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 4,588.32 мянган төгрөгөөр тооцсон.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Халхгол сумын Ялалт музей”-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 124,472.80 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	21,812.42	21,780.20	(32.22)
Үндсэн хөрөнгө	1,174,106.30	1,355,674.76	181,568.46
Хуримтлагдсан элэгдэл	(70,039.18)	(127,103.62)	(57,064.44)
Нийт хөрөнгө	1,125,880.54	1,250,353.34	124,472.80
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,125,880.54	1,250,353.34	124,472.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,125,880.54	1,250,353.34	124,472.80

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь эхний үлдэгдлээс үйл ажиллагаанд зарцуулсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө худалдан авсан, шилжүүлж авсан, шинээр түүх соёлын дурсгалт хөшөөнүүдийг бүртгэснээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 17,900.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 168,995.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 5,326.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,250,353.34 мянган төгрөг болж 124,472.80 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар "Халхгол сумын Ялалт музей" тайлант онд 6,500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 21,559.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 331.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Музейн үзвэрийн орлого	6,500.0	16,771.5	10,271.5
Буудлын орлого	0.00	1,459.5	1,459.5
Ном борлуулсан орлого	0.00	3,288.0	3,288.0
Бусад орлого	0.00	40.0	40.0
<b>Нийт дүн</b>	<b>6,500.0</b>	<b>21,559.0</b>	<b>15,059.0</b>

Өөрийн орлого 15,059.0 мянган төгрөгөөр давсан нь 2019 онд Халхголын дайны ялалтын түүхт 80 жилийн ойн баяр болж олон зочид, аялагчид ирж музейгээр үйлчлүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 124,992.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 124,992.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 124,992.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 124,370.3 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Засгийн газрын нөөц сангаас 18,170.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 26,141.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,059.0 мянга, нийт 59,370.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 59,370.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 38,308.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 28,123.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 5,786.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 28,123.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. 2019 онд нийт 32,522,270 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаас 28,525,970 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 5,786.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

**2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Нягтлан бодогчийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай гэж үзлээ.

**2.13. Шилэн дансны мэдээлэл**

“Халхгол сумын Ялалт музей” Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 128 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 869.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 869.2 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Зөвлөмж өгөөгүй байна.

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Халхгол сумын Ялалт музей” -ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.



“Зөрчилгүй” дүгнэлт

”Халхгол сумын Ялалт музей”-ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Бараа материалын данстай холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт:*

*Тайлант хугацаанд "Материал" нэртэй 5,786,796.00 төгрөгийн материал орлогодож, зарлагадсан байна.*

*1.2. Эрсдэл:*

*Бараа материалыг бөөн дүнгээр санхүүгийн программд бүртгэсэн нь тодорхойгүй. Бодитой хийгдээгүй байх эрсдэлтэй.*

*1.3. Өгсөн зөвлөмж:*

*Бараа материалыг нягтлан бодох бүртгэлд нэрээр нь тодорхой бүртгэх.*

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

*Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.*



Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,812,419.83</b>	<b>21,780,203.83</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	21,812,419.83	21,780,203.83
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21,812,419.83	21,730,203.83
35410	Бичиг хэргийн материал	1,289,607.00	1,305,207.00
35420	Аж ахуйн материал	19,765,132.83	20,186,956.83
35440	Түлш, шатах тослох материал	757,680.00	238,040.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,104,068,121.18</b>	<b>1,228,573,139.49</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,104,068,121.18	1,228,573,139.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	997,683,121.26	1,122,380,639.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	784,603,414.56	784,603,414.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,800,000.00	20,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,800,000.00)	(20,800,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,760,989.00	49,094,009.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,914,487.72)	(14,705,144.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,438,068.00	23,418,068.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,036,524.72)	(11,431,138.76)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	129,221,531.00	270,976,969.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	90,512,300.00	100,012,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,902,168.86)	(26,746,236.68)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	106,384,999.92	106,192,499.88
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(385,000.08)	(577,500.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	106,000,000.00	106,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,125,880,541.01</b>	<b>1,250,353,343.32</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,125,880,541.01</b>	<b>1,250,353,343.32</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,125,880,541.01	1,250,353,343.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	352,789,793.00	352,789,793.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	63,346,850.77	187,819,653.08
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,815,293.84)	63,346,850.77
51220	Тайлант үеийн үр дүн	69,162,144.61	124,472,802.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	709,743,897.24	709,743,897.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,125,880,541.01</b>	<b>1,250,353,343.32</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>426,038,650.04</b>	<b>353,888,779.73</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>209,819,188.04</b>	<b>176,025,379.73</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	209,819,188.04	176,025,379.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	209,819,188.04	176,025,379.73
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	6,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	206,319,188.04	169,525,379.73
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>216,219,462.00</b>	<b>177,863,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	102,757,200.00	118,492,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	102,757,200.00	118,492,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	113,462,262.00	59,370,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,000,000.00	18,170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	90,787,762.00	26,141,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,674,500.00	15,059,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>152,176,847.77</b>	<b>229,415,977.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>152,176,847.77</b>	<b>229,415,977.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	148,710,163.77	228,793,415.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	67,193,700.00	79,835,000.00
210101	Үндсэн цалин	67,193,700.00	79,835,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,004,216.00	9,942,800.00
210201	Тэтгэврийн даатгал	5,327,316.00	6,756,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	669,200.00	637,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	535,300.00	159,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	133,900.00	796,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,338,500.00	1,593,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,131,205.00	18,386,428.00
210301	Гэрэл, цахилгаан	3,051,800.00	4,200,000.00
210302	Түлш, халаалт	12,640,105.00	13,586,428.00
210303	Цэвэр, бохир ус	439,300.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,089,880.00	15,192,702.00
210401	Бичиг хэрэг	865,600.00	1,322,002.00
210402	Тээвэр, шатахуун	4,955,280.00	4,960,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	2,025,000.00	6,839,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,064,000.00	1,770,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	76,500.00	5,295,538.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	76,500.00	5,295,538.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,151,888.00	20,739,286.00
210604	Урсгал засвар	15,151,888.00	17,142,686.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	1,000,000.00	2,492,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	2,492,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,309,220.00	12,802,300.00



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	912,420.00	12,405,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,900.00	59,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	16,500.00
210807	Газрын төлбөр	42,400.00	42,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,753,554.77</b>	<b>64,107,361.42</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,250.00	1,717,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,652,304.77	62,390,361.42
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,466,684.00</b>	<b>622,562.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,466,684.00</b>	<b>622,562.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,466,684.00	622,562.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>273,861,802.27</u></b>	<b><u>124,472,802.31</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	204,975,169.92	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	204,975,169.92	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(204,975,169.92)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>68,886,632.35</u></b>	<b><u>124,472,802.31</u></b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>128,931,700.00</b>	<b>184,363,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>(87,287,762.00)</b>	<b>6,500,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	(87,287,762.00)	6,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	(87,287,762.00)	6,500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	6,500,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	(90,787,762.00)	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>216,219,462.00</b>	<b>177,863,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	102,757,200.00	118,492,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	102,757,200.00	127,272,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	113,462,262.00	59,370,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,000,000.00	18,170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	90,787,762.00	26,141,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,674,500.00	15,059,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>128,931,700.00</b>	<b>184,363,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>128,931,700.00</b>	<b>184,363,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>125,465,016.00</b>	<b>183,740,838.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	67,193,700.00	79,835,000.00
210101	Үндсэн цалин	67,193,700.00	79,835,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,004,216.00	9,942,800.00
210201	Тэтгэврийн даатгал	5,327,316.00	6,756,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	669,200.00	637,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	535,300.00	159,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	133,900.00	796,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,338,500.00	1,593,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,991,100.00	17,300,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,051,800.00	4,200,000.00
210302	Түлш, халаалт	12,500,000.00	12,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	439,300.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,300,280.00	21,499,302.00
210401	Бичиг хэрэг	725,000.00	1,389,102.00
210402	Тээвэр, шатахуун	4,955,280.00	5,732,200.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	380,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	3,000,000.00	12,878,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,240,000.00	1,200,000.00



<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	396,500.00	3,877,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,500.00	3,877,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,161,170.00	27,525,336.00
210604	Урсгал засвар	21,161,170.00	20,295,336.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.00	2,492,000.00
210702	Догоод албан томилолт	1,000,000.00	2,492,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,316,800.00	15,802,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	920,000.00	15,405,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,900.00	59,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	16,500.00
210807	Газрын төлбөр	42,400.00	42,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	101,250.00	5,467,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,250.00	5,467,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,466,684.00</b>	<b>622,562.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,466,684.00	622,562.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,466,684.00	622,562.00



#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	352,789,793.00	709,743,897.24	63,346,850.77	0.00	1,125,880,541.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>352,789,793.00</b>	<b>709,743,897.24</b>	<b>63,346,850.77</b>	<b>0.00</b>	<b>1,125,880,541.01</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>352,789,793.00</b>	<b>709,743,897.24</b>	<b>63,346,850.77</b>	<b>0.00</b>	<b>1,125,880,541.01</b>
D01	<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>352,789,793.00</b>	<b>709,743,897.24</b>	<b>63,346,850.77</b>	<b>0.00</b>	<b>1,125,880,541.01</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>352,789,793.00</b>	<b>709,743,897.24</b>	<b>63,346,850.77</b>	<b>0.00</b>	<b>1,125,880,541.01</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	124,472,802.31	0.00	124,472,802.31
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>352,789,793.00</b>	<b>709,743,897.24</b>	<b>187,819,653.08</b>	<b>0.00</b>	<b>1,250,353,343.32</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	124,992,900.00	124,370,338.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	124,992,900.00	124,370,338.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	124,992,900.00	124,370,338.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	79,670,000.00	79,047,438.00
210101	Үндсэн цалин	79,670,000.00	79,047,438.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	9,942,800.00	9,942,800.00
210201	Тэтгэврийн даатгал	6,756,000.00	6,756,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	637,400.00	637,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	159,300.00	159,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	796,700.00	796,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,593,400.00	1,593,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,300,000.00	17,300,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	4,200,000.00
210302	Түлш, халаалт	12,500,000.00	12,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,824,200.00	7,824,200.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,124,200.00	2,124,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	3,000,000.00	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,200,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,877,100.00	3,877,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,877,100.00	3,877,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,054,000.00	4,054,000.00
210604	Урсгал засвар	4,054,000.00	4,054,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,008,000.00	1,008,000.00
210702	Дотоод албан томилолт	1,008,000.00	1,008,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	1,316,800.00	1,316,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	920,000.00	920,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,900.00	59,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	16,500.00
210807	Газрын төлбөр	42,400.00	42,400.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>59,370,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>59,370,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	59,370,500.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	787,562.00
210101	Үндсэн цалин	787,562.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,675,102.00
210401	Бичиг хэрэг	189,102.00
210402	Тээвэр, шатахуун	3,608,000.00
210404	Ном, хэвлэл	9,878,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,471,336.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,750,000.00
210602	Тавилга	2,480,000.00
210604	Урсгал засвар	16,241,336.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,484,000.00
210702	Дотоод албан томилолт	1,484,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,485,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,485,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,467,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,467,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>59,370,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>59,370,500.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,141,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,059,000.00